

# Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар

2024 оны жилийн эцэс

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль							
1	1	БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ 2003-05-30 Дугаар 2003_01	15.2.3. бүс нутгийн хөгжилд улсын төсвөөс оруулж буй хөрөнгө оруулалт болон санхүүгийн бусад дэмжлэгийг зориулалтын нь дагуу үр ашигтай ашиглах;	Тус аймагт УТХО-аар хэрэгжүүлэхээр 2024 онд эрх шилжүүлэн ирсэн нийт 8 төсөл арга хэмжээг 5,434.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсанаас мөн оны тайлант үеийн байдлаар нийт 6 төсөл арга хэмжээний 3,431.4 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр хянан баталгаажуулж хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлэн олгосон бол үлдэгдэл санхүүжилтийг ондоо багтаан санхүүжүүлэхээр хүлээгдэж байна. Харин орон нутгийн төсөв, орон нутгийн авто замын сан, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 71 дүгээр тогтоолоор анх баталсан бөгөөд 2024 оны 28, 39 дүгээр тогтоолуудаар тус тус тодотгол хийсэн. Тайлант үеийн байдлаар ОНТХО-аар хэрэгжүүлж буй нийт 20 төсөл арга хэмжээнээс нийт 15 төсөл, арга хэмжээний санхүүжилт 1,419.9 сая төгрөгийг, ОНАЗС-аар хэрэгжиж буй нийт 3 төсөл, арга хэмжээний санхүүжилт 345.7 сая төгрөгийг, ОНХС-аар хэрэгжиж буй нийт 56 төсөл арга хэмжээний санхүүжилт 2,321.7 сая төгрөгийг тус тус олголоо.	100%		

				Мөн 2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан нийт төсөл, арга хэмжээнээс ОНТХО-ын 6, ОНАЗС-ийн 2, ОНХС-ийн 18 төсөл, арга хэмжээг он дамжуулан хэрэгжүүлэхээр тус тус төлөвлөлөө. Баруун бүс нутагт Говь-Алтай аймаг нь сэргээгдэх эрчим хүч, байгалийн аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх бодлогын баримт бичгийг аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган ажиллаж байна.			
	2		15.2.4.. бүс нутгийн хөгжлийн талаар хийж байгаа ажлын үр дүнг Зөвлөлд тайлагнах;	УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталсан бөгөөд бүсийн хөгжлийн талаар баримтлах бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох дээд байгууллагаас зохион байгуулсан 5 удаагийн зөвлөгөөн уулзалтад 2024 оны байдлаар тус аймгаас нийт 76 хүн хамрагдлаа. Мөн баруун бүсийн зөвлөлийн даргаар Ховд аймгийн Засаг дарга ажилладаг ба бүсийн зөвлөлөөс зохион байгуулсан арга хэмжээнд тухай бүрд нь оролцож, гарсан санал, дүгнэлтийг тухай бүр танилцуулан ажиллалаа. "Газрын тогтвортой менежмент ба нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө" баруун 5 аймгийн сургалтанд аймгийн бодлого боловсруулах , хэрэгжүүлэх түвшний ажилтнуудыг хамруулж чадавхжууллаа. Сэргээгдэх эрчим хүчний болон , байгалийн аялал жуулчлалын чиглэлээр бүс нутагтаа манлайлан ажиллах бодлыг боловсруулж ажиллаж байна.	100%		
2	3	ТӨСВИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2011-12-23 Дугаар 2015-10	14.2.11. Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг	Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн Засаг даргын 02 дугаар албан даалгавар гарган орон нутгийн төсвийн бүх шатны байгууллагыг төсвийн хэмнэлтийн горимд	70%		

			дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах;	шилжүүлж, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж байна.			
3	4	Ойн тухай /Шинэчилсэн найруулга/ 2012-05-17 Дугаар 2022.06.03	39.7. Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сум, нийслэл, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана.	Тус аймгийн хэмжээнд ой, хээрийн гал түймэр гараагүй байна. Ой хээрийн түймрээс анхааруулж сэргийлэх мэдээ мэдээллийг тогтмол орон нутгийн мэдээллийн хэрэгслүүдээр бэлтгэн хүргэж байна. Мөн хавар, намрын хуурайшилтын болон зуны хэт халалтын үед иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах чиглэлээр сэрэмжлүүлэг, сурталчилгааг 7 хоногт 1 удаа, байгууллагын цахим хуудсанд 7 хоногт 2-3 удаа мэдээлэл бэлтгэн байршуулж, сурталчилгаа, мэдээллийг тогтмол зохион байгуулсан.	100%		
4	5	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 83 сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, 3735 иргэнийг хамрууллаа. Аймгийн Цагдаагийн газартай хамтран зохион байгуулдаг авто тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодсон болон гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэн саатуулагдсан 119 иргэнд /давхардсан тоогоор/ зан үйлд нөлөөлөх 34 удаагийн сургалтыг зохион байгууллаа. “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ы хүрээнд байгууллагын цахим хуудсанд 8	100%		

		дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	удаагийн постер, видео, мэдээллийг байршуулж, нийт 2333 хүний хандалт авлаа.			
6		19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Аймгийн хэмжээнд 18 сум 2 тосгонд нийт 30 хамтарсан баг 264 гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. 2024 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 7, гэр бүлийн хүчирхийллийн зөрчил 86 дуудлага мэдээллийг хүлээн авч, 25 кейсийг хааж, 68 кейс дээр ажиллаж байна. Хамтарсан багууд нь дараах үйлчилгээг үзүүлж ажиллалаа. Үүнд: Аюулгүй байдлыг хангах үйлчилгээг 35, эмнэлгийн тусламж үйлчилгээг 12, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг 140, эрх зүйн тусалцааг 36, нийгмийн халамжийн үйлчилгээг 25, дэмжих холбон зуучлах үйлчилгээг 69 иргэнд, хүүхэд хамгааллын үйлчилгээг 54 хүүхдэд тус тус үзүүллээ. Гэр бүлийн болон хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор сумдын 30 хамтарсан багт 12,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн арга зүйгээр ханган ажиллалаа.	100%		
7		19.1.3.. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Аймгийн ГХУСАЗСЗөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолын дагуу Нэгдсэн эмнэлэг түшиглэсэн "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн салбар Улаан загалмайн хорооны дэргэдэх "Түр хамгаалах байр"-ны үйл ажиллагааг үргэлжлүүлэн 1 жилийн хугацаатайгаар сунгасан ба үүний дагуу 2024 оны 11 дүгээр сарын байдлаар түр хамгаалах байранд хүүхэд 17, насанд хүрэгч 13 нийт 30 иргэнийг 376 хоногийн хугацаанд аюулгүй байдлын хамгаалалтад авч, үйлчилгээ үзүүллээ. Тус төвийн үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 30,0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүллээ. Мөн хүүхэд хамгааллын зардлаас хүүхэд хамгааллын	100%		

			хариу үйлчилгээнд 16.9 сая төгрөгийн зардлыг олголоо. Япон Улсын Засгийн газрын “Өвсний үндэс” буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хүрээнд шинээр баригдсан “Түр хамгаалах байр”-ны барилгыг хүлээн авахаар улсын комисст хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна.			
8	19.1.4.. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 83 сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, 3735 иргэнийг хамрууллаа. Хамтарсан багийн урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор хүүхэд хамгааллын зардлаас 30 хамтарсан багт 12.2 сая төгрөгийн санхүүжилтийг олголоо. Аймгийн Цагдаагийн газартай хамтран зохион байгуулдаг авто тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодсон болон гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэн саатуулагдсан 119 иргэнд /давхардсан тоогоор/ зан үйлд нөлөөлөх 34 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Улаан загалмайн хорооны дэргэдэх "Түр хамгаалах байр"-ны үйл ажиллагаанд аймгийн ЗДТГазраас 30,0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлж, тус төвд 17 хүүхэд, 13 насанд хүрэгчийг байрлуулж үйлчилгээ үзүүллээ.	100%			
9	19.1.5.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Улаан загалмайн хорооны дэргэдэх "Түр хамгаалах байр"-ны үйл ажиллагаанд аймгийн ЗДТГазраас 30,0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлж, тус төвд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 17 хүүхэд, 13 насанд хүрэгчийг байрлуулж үйлчилгээ үзүүллээ. "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-өөр дамжуулан сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд насанд хүрэгч-51, хүүхэд-62 нийт 113 хүн хамрагдлаа. Холбон зуучлах үйлчилгээнд 40 хүнийг хамрууллаа. Гэр бүлийн боловсрол олгох	100%			

			56 удаагийн сургалт, зөвлөгөөн, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж 2466 иргэнийг хамрууллаа. Хүүхэд хүмүүжлийн эерэг аргын 36 удаагийн сургалтыг зохион байгуулж 780 эцэг эх, асран хамгаалагчдыг хамрууллаа.			
10		19.1.6.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:	Сумдад хохирогчид зөвлөгөө өгөх уулзах өрөө танхим байхгүй.Аймгийн төвд хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газарт Гэр бүлд зөвлөгөө өгөх төв” ажиллаж байгаа ба сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд насанд хүрэгч-51, хүүхэд-62 нийт 113 хүн хамрагдлаа	100%		
11		19.1.7.. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн эерэг харилцааг бий болгох, эцэг эхийн хамтын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, уламжлалт өв соёлоо дээдлэн өрх бүр угийн бичгээ хөтөлж үр хүүхдүүддээ өвлүүлэх, гэр бүлийн боловсролоор дамжуулан гэр бүлийн хөгжил, хамгаалал, оролцоог бэхжүүлэх зорилготой "ХАМГИЙН ДУЛААХАН ГАЗАР" аймгийн гэр бүлийн зөвлөгөөнийг аймгийн Засаг даргын тамгын газар, Монголын Эмэгтэйчүүдийн холбооны Говь-Алтай салбар, Дэлхийн Зөн ГААОНХөтөлбөр, Соёл, урлагийн газар, Насан туршийн суралцахуйн төв, Монгол банк, Эртэч Монгол академи зэрэг байгууллагууд хамтран зохион байгууллаа. Зөвлөгөөнд сум, баг, байгууллагадаа эерэг үлгэр дуурайллыг түгээн дэлгэрүүлдэг, манлайлагч, угийн бичгээ үлгэр	100%		

				жишээ хөтөлдөг нийт 300 хүн оролцлоо."Гэр бүл хамтын үүрэг" сэдэвт хэлэлцүүлгийг өрнүүлж, оролцогчдын санал хүсэлт, сэтгэгдлийг сонслоо. Эцэг эхийн үүрэг, оролцоо тэнцвэртэй байснаар хүүхдийн хүмүүжил төлөвшилд хэрхэн эерэгээр нөлөөлдгийг дасгал ажлаар дамжуулан оролцогчдод ойлгуулан "Гэр бүлдээ цаг гаргая" уриалгад нэгдэж, гэр бүлийн гишүүн бүр хэрэгжүүлэх боломжтой дүрмийг баталлаа. "Хамгийн дулаахан газар" арга хэмжээний хүрээнд гэр бүлийн зөвлөгөөнд оролцсон 150 өрхөд "Жендэр ба гэр бүл", төрийн байгууллагын 200 албан хаагчдад сэтгэл зүй, гэр бүлийн боловсролын талаар мэдээлэл өгч, "Амьдралыг хамтдаа урлая" сургалтад 52 хосыг хамрууллаа. Энэ арга хэмжээг зохион байгуулсан аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөлд орон нутгийн төсвөөс 4,5 сая төгрөгийн дэмжлэг олголоо.			
	12		19.1.8.. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	"Гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-өөр дамжуулан сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд насанд хүрэгч-51, хүүхэд-62 нийт 113 хүн хамрагдлаа. Холбон зуучлах үйлчилгээнд 40 хүнийг хамрууллаа. Гэр бүлийн боловсрол олгох 56 удаагийн сургалт, зөвлөгөөн, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж 2466 иргэнийг хамрууллаа. Хүүхэд хүмүүжлийн эерэг аргын 36 удаагийн сургалтыг зохион байгуулж 780 эцэг эх, асран хамгаалагчдыг хамрууллаа. Аймгийн хэмжээнд гэр бүлийн боловсрол олгох 86 удаагийн аян, сургалт, зөвлөгөөн, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 8281 иргэн, 6590 гэр бүл буюу нийт гэр бүлийн 40.1%-ийг хамрууллаа.	100%		
5	13	Хоршооны тухай /Шинэчилсэн	43.2.1. хоршоог дэмжих, хоршооны үйл ажиллагаатай	"Хоршооны тухай хууль", "Хоршоо хөгжүүлэх сан" бусад тогтоомжийг сурталчлах, хоршоодыг	100%		

		найруулга/ 2021-05-06 Дугаар 2021.05.06	холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	чадавхжуулах, иргэдэд хоршооны тухай мэдлэг олгон, хоршоо үүсгэн байгуулахад зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг төлөвлөн зохион байгууллаа. Тухайлбал: Тогтвортой ноос, ноолуур эвсэл, “Нутгийн үйлс” сургалт судалгааны төвтэй хамтран “Мал аж ахуй эрхлэх ноолуур бэлтгэх зохистой дадал”, “Ноолуур ангилан бэлтгэгч” сургалт, “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд шинээр байгуулагдсан хоршоодод зөвлөн туслах, тогтвортой байдлыг хангах, хоршооны түүхий эд борлуулалт болон бүтээгдэхүүн хөгжүүлэлт, өртгийн сүлжээнд тулгарч буй асуудлыг тодорхойлж, дэмжлэг үзүүлэх сургалтуудад нийт 1800 хүн хамрагдлаа. Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байгаа хоршоодын үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх зорилгоор шалгаруулдаг “Улсын тэргүүний хоршоо” шалгаруулах журмын дагуу “Сулэн дэнж” хоршооны материалыг бүрдүүлэн хүргүүллээ. Тус шалгуурыг “Сулэн дэнж” хоршоо хангаж “Улсын шилдэг хоршоо”-гоор шалгарсан. Аймгийн хэмжээнд 2024 онд нийт 500 гаруй хоршоо шинээр байгуулагдлаа.			
6	14	Төрийн хэмнэлтийн тухай 2022-04-29 Дугаар 2022.04.29	13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох; (13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах; 22.1.Энэ	Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Говь-Алтай, Баян-Уул сум/, Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Говь-Алтай, Тайшир сум/ тендер шалгаруулалтыг 2024 оны 05 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулсан. Ентүм зочид буудлаас 3,4 дүгээр байрны хойд талын уулзвар хүртлэх авто замын тендерийг 2024 оны 05 сарын 01-ний дотор худалдан авах ажиллагаа зохион байгуулсан боловч оролцогч тал гомдол гаргасны улмаас	100%		



		хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.)	шүүхийн шатанд шийдвэрлэгдэж, дахин зарласан бөгөөд гүйцэтгэгч нь шалгарсан байна.			
15		8.1. Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно. (Энэ хуулийн 8.1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн өмсгөл, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д заасан тусгай хувцас хамаарахгүй)	2024 онд орон нутгийн төсвийн 47 байгууллагын хувьд төсвийн хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан аваагүй энэ талаар тендер зарлаагүй болно.	100%		
16		14.2. Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлтийг оруулахдаа ХААГ-ын захиалагчийн эрхээр хянаж холбогдох албан бичгийг tender.gov.mn цахим системээр хүлээн авч тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа 29 байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хянаж, нэмэлт өөрчлөлтийг тухай бүр нь хянаж баталгаажуулж байна.	100%		

17		14.4. Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.	Тайлант онд цахим дэлгүүрээр бараа ажил үйлчилгээ худалдан аваагүй байна.Ерөнхий гэрээний аргын зааварчилгааг сумдын Засаг дарга, санхүүгийн албаны дарга, ЗДТГ-ын дарга нийт 54 албан хаагчийг оролцуулан 2024 оны 03 дугаар сард сургалтыг зохион байгуулсан. Мөн Худалдан авах ажиллагааны газрын 70484647 дугаарын утсаар ажлын 5 хоног тутам худалдан авах ажиллагаа хариуцсан 4 мэргэжилтэн тогтмол мэдээлэл өгөн ажиллаж байна. Тус оны 05, 12 саруудад аймгийн Төрийн сангийн мэргэжилтнүүд, Төрийн Аудитын газарт мэдээлэл хүргэлээ.	100%		
18		14.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 120 төсөл, арга хэмжээнээс 17-н төсөл арга хэмжээг шууд худалдан авалтаар, үлдсэн 103 төсөл арга хэмжээг тендер шалгаруулалтаар зохион байгуулахаар баталсан. Жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөнд тусгагдсан нийт төсөл арга хэмжээнээс 99 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын үнэлгээний хороо байгуулагдаж, тендер шалгаруулалтын нээлт хийгдэж цахим системд үр дүнг нийтэлсэн нийт 84, үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулсан 15 төсөл арга хэмжээ байна. Мөн 2024 онд худалдан авах ажиллагаатай холбоотой шүүхийн шатанд 1, Сангийн яаманд 4, нийт 5 гомдол, маргаан гарсныг Шүүх болон Сангийн яам хянан үзээд Захиалагчийн талд шийдвэрлэсэн байна.	100%		
19		15.2.1. Байгууллагын цахилгаан, дулааны эрчим	Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд цахилгааны тоолуураар төлбөр , тооцоо хийж байна. Дулааны	70%		

		хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх; (15.2.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана)	тоолуур суурилуулах чиглэлээр холбогдох байгууллагуудад чиглэл хүргүүлэн бэлтгэл ханган ажиллаж байна. Одоогоор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар , Хас банк зэрэг байгууллагууд дулааны тоолуураар төлбөр төлж байна. Аймгийн ЗДТГ дулааны тоолуур суурилуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.			
20		15.2.2.. Нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах;	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай” 144 дүгээр тогтоол, Эрчим хүчний сайдын 2020 оны 111 дүгээр тушаалаар баталсан төлөвлөгөөний дагуу аймгийн төсвийн байгууллагуудад дулааны тоолуур суурилуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн холбогдох байгууллагуудад чиглэл хүргүүлж, бэлтгэл ханган ажиллаж байна. Аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар болон Хас банк зэрэг байгууллагууд дулааны тоолуураар төлбөр тооцоогоо хийж ашиглаж байна.	70%		
21		15.2.4.. цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх;	Аймгийн хэмжээнд төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем egr.e-mongolia.mn болон docx.gov.mn дундын системийг ашиглан төрийн бүх байгууллагууд албан бичиг боловсруулах, илгээх, солилцох үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Прокурорын газар, Шүүхийн шинжилгээний хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг албан байгууллагууд тоон гарын үсэг ашиглан өдөр тутамдаа албан бичгээ цахимаар солилцон бичиг хэргийн зардлыг хэмнэн ажиллаж байна. Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн сар, улирал, хагас, бүтэн	100%		

				жилийн хэрэгжилтийг холбогдох дээд шатны байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээний <a href="http://new.unelgee.gov.mn">new.unelgee.gov.mn</a> цахим системээр тайлагнан ажиллаж байна.			
	22		15.2.7.. сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх.	Тайлант онд төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалт, удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөн, сум агентлагийн удирдлагуудтай хийх уулзалт, аймгийн онцгой комиссын хурал зэргийг цахимаар зохион байгуулж зардлыг 1323.4 сая төгрөгөөр, бичиг хэрэг, албан томилолт, гадаад албан томилолт, багаж техник хэрэгсэл худалдан авах зардлыг 1080.5 сая төгрөгөөр тус тус бууруулан ажиллалаа.	100%		
	23		15.2.5.. хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;	2024 оны жилийн эцсийн гүйлгээ хаагдаагүй, төсвийн гүйцэтгэлийн мэдээ гараагүй байна.	Х.Б		
7	24	Үндэсний их баяр наадмын тухай /шинэчилсэн найруулга/ 2022-06-28 Дугаар 2022.06.28	5.4. Энэ хуулийн 5.3-т заасан нөхцөлд аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх хугацааг 08 дугаар сарын 10-ны өдрөөс хэтрүүлэхгүй байхаар тогтооно. (5.3.Онцгой нөхцөл байдлаас шалтгаалан энэ зүйлийн 5.2-т зааснаас өөр өдрүүдэд улс, аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх бөгөөд улс, аймгийн баяр наадмын хугацааг Засгийн газар, сумын баяр наадмын	2024 онд тус аймгийн 16 сумын тэгш ой тохиож тус бүр 100.0 сая төгрөгийн дэмжлэг нийт 1600.0 сая төгрөгийн дэмжлэг орон нутгийн төсвөөс олгож сумын баяр наадмыг тэмдэглэх хугацааг 08 дугаар сарын 10-ны өдрөөс хэтрүүлэхгүй байхаар тогтоож хэрэгжүүллээ.	100%		

			хугацааг аймгийн Засаг дарга тогтооно.)				
8	25	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-07-05 Дугаар 2023.01.01	15.7. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байрны байршил, аймаг, нийслэлийн саналыг харгалзан хүнс, эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтооно.	Архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 187 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс худалдах 159, үйлчлэх 28 байна. Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрлийг олгож байна. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан 2023 оны А/470/А-327/А-306 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд тус аймагт өнөөдрийн байдлаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоо хэтрээгүй байгаа болно.	100%		
	26		23.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно.	Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/199 дүгээр захирамжаар аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтоолоо.	100%		